



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОНТ
**АРСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 4/02

Улаанбаатар хот

Архивын баримт хүлээн авах хуваарь
батлах, баримт нягтлан шалгах комисс
шинэчлэн байгуулах тухай

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 15 дугаар зүйлийн 15.5, 15.6.3, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалт, 25 дугаар зүйл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 3.6, 3.7, 3.8, 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Хуульд заасан чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг жил тутам батлуулж, үйл ажиллагааг тайлагнан ажиллахыг Баримт нягтлан шалгах комисст даалгасугай.

2.Байгууллагын “Баримт нягтлан шалгах комисс”-ын бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн байгуулсугай.

3.Байгууллагын тасаг, нэгж, ажилтан албан хаагчдаас эмхлэн цэгцлэгдсэн, бүрэн бүтэн бүрдэл бүхий архивын баримтыг бүртгэлээр хүлээн авах 2024 оны жагсаалтыг хавсралтаар баталсугай.

4.Архивын баримтыг стандарт шаардлагад нийцүүлэн нягтлан шалгаж авахыг Архивын ажилтан /Т.Мөнхцацрал/-д даалгасугай.

5.Архивын болон комиссын үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай зардлыг гаргахыг Санхүүгийн албаны дарга (Б.Мядаг)-д зөвшөөрсүгэй.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга /Б.Однаран/-д үүрэг болгосугай.

7.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан төвийн Захирлын 2019 оны А/19 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Ц.УРАНЧИМЭГ

1424100003

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын 2024 оны 01 дүгээр сарын 05 -ний
өдрийн 1/02 дугаар тушаалын хавсралт



АӨСҮТөвийн 2024 онд үүссэн баримт бичгийг
архивд хүлээн авах хуваарь

№	Тасаг нэгж	Хөтлөгдөх хэргийн тоо	Баримт хүлээн авах эцсийн хугацаа
1	Стратеги төлөвлөлтийн алба	10	2024.03.12
2	Хүний нөөцийн алба	3	2024.03.12
3	Санхүүгийн алба	12	2024.03.29
4	Чанарын алба	1	2024.03.14
5	Сувилахуйн алба	1	2024.03.14
6	Сургалтын алба	2	2024.03.15
7	Тархвар судлаач	1	2024.03.20
8	Захирлын туслах	3	2024.03.12
9	Лабораторийн тасаг	3	2024.03.21
10	Эмзүйн алба	1	2024.03.19
11	Поликлиникийн тасаг	1	2024.03.18
12	Бусад тасаг нэгж	1	2024.03.27

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын 2024 оны 07 дүгээр сарын 05 -ний
өдрийн 1/02 дугаар тушаалын хавсралт



Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:

Үйл ажиллагаа эрхэлсэн Дэд захирал

Гишүүд:

Хүний нөөцийн албаны дарга

Ерөнхий нягтлан бодогч

Мэдээлэл, технологийн албаны дарга

Аж ахуйн албаны дарга

Захирлын туслах, бичиг хэргийн ажилтан

Нарийн бичиг дарга:

Архивч, номын санч